



# МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙДЫН ЗАХИРАМЖ

2017 оны 5 дугаар  
сарын 3-ны өдөр

Дугаар 76


Улаанбаатар  
хот

Захирамжид өөрчлөлт оруулах тухай

“Зөвлөл байгуулах тухай” Ерөнхий сайдын 2017 оны 2 дугаар сарын 15-ны өдрийн 38 дугаар захирамжийн 1 дүгээр зүйлийг дор дурдсанаар өөрчилсүгэй:

“1. Монгол Улсын үнэлэмж, байр суурь, монгол хүний үнэ цэнийг нэмэгдүүлэх, Монгол Улсыг дэлхийд таниулах бүтээгдэхүүн, үйлчилгээг тодруулах, сурталчлах бодлогыг зохицуулах үүрэг бүхий “Монголын үндэсний брэндийн зөвлөл”-ийг дараах бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай:

- |           |  |
|-----------|--|
| Дарга     | -Монгол Улсын Ерөнхий сайд   |
| Дэд дарга | -Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга   |
| Гишүүд:   | -Байгаль орчин, аялал жуулчлалын сайд;<br>-Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд;<br>-Гадаад харилцааны дэд сайд;<br>-Хууль зүй, дотоод хэргийн дэд сайд;<br>-Хөдөлмөр, нийгмийн хамгааллын дэд сайд;<br>-Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын дэд сайд;<br>-Уул уурхай, хүнд үйлдвэрийн дэд сайд;<br>-Зам, тээврийн хөгжлийн дэд сайд;<br>-Барилга, хот байгуулалтын яамны Төрийн нарийн бичгийн дарга;<br>-Эрчим хүчний яамны Төрийн нарийн бичгийн дарга;<br>-Үндэсний хөгжлийн газрын дарга;<br>-Нийслэлийн Засаг даргын Дэд бүтэц, гэр хорооллын хөгжлийн асуудал хариуцсан орлогч.<br>-Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дэд дарга.” |



Ж.ЭРДЭНЭБАТ